



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 - оны 06 сарын 17 өдөр

Дугаар A/325

Хэрлэн сум

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 3 дугаар сарын 11-ний "Төлөвлөгөө батлах тухай" А/90 дүгээр тушаал, Засгийн газрын 2022 оны 2 дугаар сарын 23 ны "Хоршооны хөгжлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай" 81 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2022 оныг "Хоршооны хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан хорын ооллын хөдөлгөөнийг эрчимжүүлэх сурталчлах, шилдэг туршлагыг дэлгэрүүлэх ажлыг аймгийн хэмжээнд өрнүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, бүтээлч ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг холбогдох төлөөллүүдийг хамруулан хуваарийн дагуу зохион байгуулж, үр дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны дөрөвдүгээр улиралд багтаан танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

